

Ажлын гэрээ хийх үед юун дээр анхаарах хэрэгтэй вэ?

Ойлгохгүй байгаа ямар ч баримтанд гарын үсгээ зурах болохгүй бөгөөд гэрээг зөвхөн чех хэлээр хийсэн байвал та орчуулгыг нь шаардах хэрэгтэй.

Хувийн бичиг баримтаа өөр бусдад огт өгч болохгүй.

Гэрээнд гарын үсэг зурахын өмнө ажил олгогч талыг албан ёсны болон найдвартай байдлыг баталгаажуулах хэрэгтэй.

Та өөрийн ажиллах ажлын байр, цалин, орон байрны талаар аль болох ихийг олж мэдээрэй.

Хэрвээ ажил олгогчтой хийх гэрээнд ямар нэг эргэлзээтэй зүйл гарвал уг гэрээг байгуулах үедээ төрийн болон төрийн бус байгууллагуудаас тусламж хүсээрэй.

Эрүүл мэндийн даатгал

Чех улсад хуулийн дагуу урт, богино хугацаагаар амьдарч буй гадаад иргэн нэг бүр аль нэг төрлийн эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах ёстой байдаг.

Тус улсад ажлын гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа бол таны эрүүл мэндийн даатгалыг ажил олгогч тань төлөх ёстой байдаг бөгөөд ажилд орсноос тань хойш тун удалгүй танд эрүүл мэндийн даатгалын картыг тань өгөх ёстой.

Та тус улсад хувиараа хөдөлмөр эрхлэдэг бол та эрүүл мэндийн даатгалаа хувиараа төлөх ёстой.

Эрүүл мэндийн хэд хэдэн төрлийн даатгал байдаг бөгөөд ямар нэг зүйл тохиолдоход илүү хүртээмжтэйг нь бодолцож бүрэн эмчилгээний даатгалыг сонгоорой.

Хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг тэдний эцэг эх нь төлөх ёстой байдаг.

Ажлын визээ сунгуулах

Ажлын виз хугацаатай байдаг бөгөөд зөвхөн хүчинтэй визийг сунгуулж болно. Хөдөлмөрийн биржийн олгосон ажил эрхлэх зөвшөөрлийг хавсарган визнийхээ хугацааг дуусахаас 14 хоногийн өмнө Гадаадын цагдаагын байцаах газар сунгуулах өргөдлөө өгөх хэрэгтэй.

Хэрэв таны виз ямар нэгэн шалтгаанаар цуцлагдсан бол эх орондоо – Монголд буцаж очиж, дахин виз хүснэ.

Хүний наймаанд өртөгсдийг хамгаалах хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрт хүний наймаанд өртөгдөж хохирсон ЧУ-ын иргэн болон гадаадын иргэдэд хамрагдана.

Хүний наймааг хууль бусаар хөдөлмөр эрхлүүлж, бэлгийн үйлдэл буюу секс хийлгэж дарангуйлан мөлжлөх зорилгоор хийдэг бөгөөд энэ нь хүнд ноцтой гэмт хэрэгт тооцогдоно.

Чех улсад хөдөлмөр эрхлэдэг гадаад иргэдийн тоо хурдацтай өсөж байгаатай зэрэгцэн тэдний хүний наймаанд өртөж, хохирогч болох эрсдэл өсөн нэмэгдсээр байна.

Хүний наймааны хохирогчид уг хэргийн талаар болон ямар байдлаар яаж илрэх тухай хомс мэдлэгтэй байдаг.

Хүний наймааны гол илэрлүүд:

- Хүсээгүй ажлыг тань хийхийг тулган шаардаж ажлуулах;
- Хувийн бичиг баримтыг нь хурааж барьцаалах;
- Гэрээнд зааснаас бага цалин олгох;
- Таныг болон таны гэр бүлийг айлган сүрдүүлэх зэрэг болно.

Хэрэв дээр дурдсан байдалд та орж байсан бол та хүний наймааны хохирогч байж болно.

Та өөрийн эрхээ хамгаалж аль нэг төрийн бус байгууллага болон ЧУ-ын цагдаагын газраас тусламж эрээрэй!

Чех улсын засгийн газраас хүний наймааны золиос болсон хүмүүст туслах тэднийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа.

Тус хөтөлбөрийг дараахи төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна.

Ла Страда ТББ хөдөлмөр, сексийн мөлжлөгт өртөгсдөд туслах:
SOS Tel: +420 222 717 171

Сексийн мөлжлөгт өртөгсдөд туслах **Магдала** төсөл,
Tel: 420 737 234 07

Гадаад иргэдэд зөвөлгөө, үйлчилгээ үзүүлдэг чехийн ашгийн бус байгууллагуудын жагсаалт

Дүрвэгсдэд зөвөлгөө өгөх газар (PPU)

Senovážná 2, Praha, 110 00; Tel: +420 224 22 43 79
www.uprchlici.cz

Иргэншил, иргэний эрхийн талаар зөвлөлгөө өгөх газар

Ječná 7, Praha, 120 00; Tel: +420 270 003 289,
Mobil: +420 776 882 774
www.poradna-prava.cz

Дүрвэгсдэд тусламж үзүүлэхэд зориулсан байгууллага (OPU)

OPU Praha - Kovářská 4, Praha, 190 00; Tel: +420 284 683 545
www.opu.cz

Дасан зохицолын асуудлаархи зөвөлгөө өгөх төв

Kubelíkova 55, Praha, 130 00; Tel: +420 222 713 332
www.cicpraha.org

Харита Праха - Гадаад иргэд болон дүрвэгсдэд зөвөлгөө өгөх газар

Pernerova 20, Praha, 180 00; Tel: +420 224 813 413
www.charita-adopce.cz

Харита Литомершицэ - Дүрвэгсдэд болон

гадаад иргэдэд зөвөлгөө өгөх газар
Dómské náměstí 10, Litoměřice, 412 01;
Tel: +420 416 731 452
www.dchltm.cz

Харита Ческа Липа - Удаан хугацаагаар

оршин суух гадаад иргэдэд зөвөлгөө өгөх газар
Dubická 2189, Česká Lípa, 470 01
Tel: +420 487 823 922, Mobil: +420 774 116 412
www.farnicharita.sf.cz

Харита Храдэц Краловэ - Гадаад иргэд болон

дүрвэгсдэд зөвөлгөө өгөх газар
Velké náměstí 37, Hradec Králové, 500 01;
Tel: +420 495 063 135
www.hk.caritas.cz

Харита Плзен - Гадаад иргэд болон

дүрвэгсдэд зөвөлгөө өгөх газар
Cukrovarská 16, Plzeň, 301 00; Tel/Fax: +420 377 441 736
www.charita.cz/dchplzen

Харита Ческе Будёевице - Дүрвэгсд болон

Гадаад иргэдэд зөвөлгөө газар
Kanovnická 16, České Budějovice, 370 01;
Tel: +420 386 351 125; www.charitacb.cz

Харита Св. Алэксандра - Гадаад иргэд болон дүрвэгсдэд зөвөлгөө газар Острава

Jeremenkova 8, Ostrava – Vítkovice, 703 00
Tel: +420 596 611 207; www.charitasvalexandra.cz

Харита Брно - Гадаад иргэдэд зөвөлгөө өгөх газар Брно

Šumavská 33, Brno, 602 00
Tel: +420 549 133 494, Mobil: +420 603 157 640
www.dchbrno.charita.cz

Харита Бланско – гадаад иргэдэд зөвөлгөө өгөх

Komenského 19, Blansko, 678 01;
Tel/Fax: +420 516 417 351
www.blansko.caritas.cz

Ла Страда Чех Улс ТББ

Tel. kancelář Praha +420 222 721 810
Tel. Info/SOS: +420 222 717 171
www.strada.cz

Найдвар төв

U Bulhara (pod Severojižní magistrálou), Praha 2
Tel: +420 212 237 343, +420 222 521 110
www.nadeje.cz

Ческү Хелсинскү вүбор

Štefánikova 216/21, Praha, 150 00; Tel: +420 220 515 188
www.helcom.cz

Бэркат

Rumunská 24, Praha 2, 120 00
Tel/Fax: +420 222 519 427, Mobil: +420 739 03 73 53
www.berkat.cz

SOZE – Цагаачлалчидтай ажиллах иргэдийн эвсэл:

Kancelář Brno: Mostecká 5, Brno, 614 00
Tel: + 420 545 213 643

SOZE – Оломоуц дах салбар:

Ostružnická 28, Olomouc, 772 00
Tel: + 420 585 242 535; www.soze.cz

Гүүр хүний эрхийн ТББ

ř. 17. listopadu 216, Pardubice, 530 02
Tel: +420 467 771 170, Mobil: +420 732 754 239
www.mostlp.org

Дасан зохицолын асуудлаархи зөвөлгөө өгөх газар

Senovážná 2, Praha 110 00
Tel: +420 224 216 758, Mobil: +420 603 281 269
www.p-p-i.cz

Жебрик – гадаад иргэдэд дэмжлэг; үзүүлэх төв

Olomouc, Voskovcova 8, 779 00
Prostějov, Vrahovická 83, 798 11
Mobil: +420 777 147 151
www.zebrik-os.cz

Чех Улс дахь Харита төрийн бус байгууллагаас**Чехэд ажиллаж амьдарч байгаа Монголчууд зөвлөлгөө авах утас**

Tel: +420 733 67 66 67; pondělí a středa: 9-11 hod., 14-16 hod.
Tel: +420 720 545 357; sobota: 10-12 hod., 14-16 hod.
Мэдээлэх үйлчилгээ үнэ төлбөргүй байна. Харин Та манай утсанд хандахдаа аль оператораар /O2, T-мобиль, Водафоне гм./ дамжихаас шалтгаалан залгасан төлбөрөө л төлнө.

Та өөрийн асуултыг монгол хэлээр доорхи и-мэйл хаягаар бидэнд ирүүлж болно: mongol.ifo@charita.cz
Chat: Yahoo: mongol.info

Шилжин суурьших асуудлаархи Олон улсын байгууллага

Dukelských hrdinů 35, Praha, 170 00
Tel: +420 233 370 160
www.iom.cz
www.domavcr.cz

Энэхүү материалыг Шилжин суурьших асуудлаархи Олон улсын байгууллагын Прага хот дахь салбараас бэлтгэн гаргаж ЧУ-ын дотоод хэргийн яамнаас санхүүжүүлэв.



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



IOM International Organization for Migration
IOM Mezinárodní organizace pro migraci

Чех улсад ажиллаж байгаа Монгол ажилчидад – ажлын шугамаар цагаачлахад зориулсан мэдээлэл

Чех улсад амьдардаг гадаад ажилчин бүр тус улсын хуулиас өөрийн эрх, үүргийн тухай олж мэдэх нь тун чухал юм.

Чех улсад хуулийн дагуу амьдрахад нэн хэрэгтэй зүйл нь ЧУ-ын хууль тогтоомжийг мэдэж биелүүлэх бөгөөд аливаа асуудал үүссэн үед хууль, эрх зүйн мэдлэггүй байсныг уучилахгүй.

Чех улсын нийгмийн бүтэц тогтолцоо, төр нийгмийн байгууллагуудын үйлчилгээ, төрийн бус байгууллагуудын талаар мэдлэгтэй байх нь ялангуяа гэр бүлээрээ амьдардаг гадаад иргэдэд тус улсад амьдрахад тус дөхөм болдог.

Тус улсад албан ёсоор оршин суух зөвшөөрөл авах, үүнтэй холбогдох асуудлуудыг шийдвэрлэх зорилгын хүрээнд гадаад иргэдэд зориулсан үнэ төлбөргүй зөвлөгөө, хэлний курс, болон гэр бүлийн аливаа асуудал мөн ажил хайх зэрэгт тусламж, дэмжлэг үзүүлдэг ашгийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг билээ.

Энэхүү төрийн бус байгууллагуудын үйлчилгээ нь янз бүрийн „klient“ гэгч зуучлагч нараас илүү үр дүнтэй бөгөөд үнэ төлбөргүй.

Та итгэж найдах хувь хүн, албан байгууллагыг сонгохдоо нилээн их анхаарал тавих хэрэгтэй. Өөрт тулгарсан нөхцөл байдлын талаар мэргэжлийн байгууллагад хандах нь хувь хүнд хандсанаас илүү үр дүнтэй.

Ажилд зуучлалын товчоогоор дамжуулан ажил хөдөлмөр эрхлэх, түүнд хэт хамааралтай байх нь ажлын хөлсөө тэдэнд алдаж, авч чадахгүй болох, визний асуудалд орж бүр цаашлаад эрүүл мэндээрээ хохирч, бусдын эрхэнд орж боолчлогдох зэрэг байдалд хүрч болох эрсдэлтэй.